

## **Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл**

Тус нэгдэл нь 1991 онд Октябрийн районы Эрүүл мэндийн зөвлөх төвөөс Эрүүл мэндийн 7 дугаар төв нэртэйгээр салж, 1997 онд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл болон өргөжиж одоо дүүргийн 160649 гаруй хүн амд эмнэлгийн анхан болон хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ үзүүлж байна.

1999 онд насанд хүрэгчдийн 50 ортой дотор, мэдрэлийн чиглэлийн нэгдсэн эмнэлэг шинээр байгуулагдсан, 2001 оноос 20 өрхийн эмнэлэг байгуулагдаж, Эрүүл мэндийн 6-р төв нэгдсэнээр дүүргийн хүн амд эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон. Нэгдсэн эмнэлэг нь 45 ортой, дүүргийн хэмжээнд 15 хорооны 125000 хүн амд дотор, мэдрэлийн чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон.

Одоо Эрүүл мэндийн нэгдэл нь захиргаа, санхүү, аж ахуйн, поликлиник, салбар амбулатори, нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг гэсэн 5 бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг болсон. Нийт 345 эмч ажилчдаас зэрэгтэй эмч 35, эрүүл мэндийн тэргүүний ажилтан 16, бакалавр зэрэгтэй сувилагч 5 ажиллаж байгаа Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан нэг төрөн гарсан билээ.

### **Байгууллагын үндсэн чиг үүрэг**

Дүүргийн хүн амд эмнэлгийн анхан болон хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг ёс зүйтэй орчинд чанартай, хүртээмжтэй, аюулгүй, хөнгөн шуурхай хүргэхэд оршино.

### **Бүтэц зохион байгуулалт**

1. Поликлиник

Нарийн мэргэжлийн үзлэгийн 32 кабинет

Оношлог-ооны 6 кабинет

Нэгдсэн ариутгал

Хүүхдийн яаралтай түргэн тусламж

### **2. Салбар амбулатори**

Нарийн мэргэжлийн үзлэгийн 28 кабинет

Оношлог-ооны 4 кабинет

### **3. Нэгдсэн эмнэлэг 45 / ортой / дотор, мэдрэл/**

Өрхийн 21 эмнэлэг

ЗАА-н тасаг

бусад

Хүний нөөц хөгжлийн алба

Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанарын алба

Сувилгааны алба

Дүн бүртгэл статистик

ЭМН-н үйл ажиллагаа

Анхан шатны тусламж үйлчилгээг өрхийн эмнэлгээр хүргэх

Бүх төрлийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэх

0-15 насны хүүхдүүдийн дархлаажуулалт

Хоёр дахь шатлалын эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ

Үйл оно-шийн болон лабораторийн оношлог оо шинжилгээ

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Дотор мэдрэл, эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ

Үндэсний болон хөтөлбөрийн хэрэгжилт

Эрүүл мэндийн үзүүлэлтүүд

Хүн амын цэвэр өсөлт 4% өссөн

Хүн амын төрөлт 3.59%

Нас баралт 0.41%

Нялхсын эндэгдэл 16.06%

Эхийн эндэгдэл 0.8%

Халдварт өвчин 76.45% буурсан байна.

1991-1995 он хүртэл байгууллагын дагаар Б.Барай ажилласан

1995 онд Эрүүл мэндийн зөвлөх төв

1997 онд Эрүүл мэндийн нэгдэл даргаан Ж.Эрхэмбаяр ажиллаж байсан

2005 оноос одоог хүртэл С.Туул ажиллаж байна.

Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хамтарсан "Эрүүл мэндийн салбарын хөгжил" хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан 20 өрхийн эмнэлгийн шинээр зохион байгуулан бүх өрхийн эмнэлгүүд байртай болсон.